



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 605

Улаанбаатар хот

“Инвескор ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон
гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.9, 62 дугаар зүйлийн 62.2, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 3.10, 6.1, 7.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Инвескор ББСБ” ХК-ийн хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргах 12-24 сарын хугацаатай, жилийн 15-18 хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000.0 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 500,000.0 (таван зуун мянга) ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар (Б.Дөлгөөн)-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д зөвшөөрсүгэй.

2. Хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 6.13-д заасны дагуу анхдагч зах зээлд санал болгохыг зөвшөөрч, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг уг ажиллагаа эхлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө тухай бүр Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ), “Инвескор ББСБ” ХК (Д.Баясгалан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.2-т заасан тодорхойлолт, мөн хуулийн 12.5-д заасан дүгнэлтийг тухай бүр Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК (Х.Алтай)-д үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон худалдаалах өрийн хэрэгслийг хэсэгчлэн гаргаж, тухай бүр 100 (нэг зуу) хувь зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасны анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тухай бүр авахыг “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ), “Инвескор ББСБ” ХК (Д.Баясгалан)-д тус тус үүрэг болгосугай.

5. Хөтөлбөрийн хүрээнд өрийн хэрэгслийг нийтэд санал болгон гаргаж, тухай бүр анхдагч зах зээлийн арилжааг амжилттай явагдсанд тооцох хүртэлх хугацаанд арилжаанаас олсон орлогыг тухай бүр тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д үүрэг болгосугай.

6. Хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн арилжааны тайланг тухай бүр анхдагч зах зээлийн арилжаа дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэн, үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулж, улирал тутам холбогдох тайланг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Инвескор ББСБ” ХК (Д.Баясгалан), “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

7.Хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын 7.1.2-т “гаргасан өрийн бичгийг өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа нь 50 хувиас хэтрэхгүй байх” гэсэн шаардлагыг тухай бүр өрийн хэрэгслийг гаргахаас өмнө болон гаргасны дараа тогтмол хангаж ажиллахыг “Инвекор ББСБ” ХК (Д.Баясгалан), “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ), хэрэгжилтэд хяналт тавихыг Үнэт цаасны газар (Б.Дөлгөөн), Банк бус санхүүгийн байгууллагын газар (Б.Итгэлсүрэн), Хяналт шалгалт, зохицуулалтын газар (Б.Долгорсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

8.Хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан банк бус санхүүгийн байгууллагын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангуулж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК (Х.Алтай), “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ), Хяналт шалгалт, зохицуулалтын газар (Б.Долгорсүрэн)-т тус тус даалгасугай.

9.Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 4.3.2-т заасан хугацаанд хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг олон нийтэд танилцуулж, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулж чадаагүй нөхцөлд зарагдаагүй үлдсэн өрийн хэрэгслийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг “Инвекор ББСБ” ХК (Д.Баясгалан), “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ)-д тус тус мэдэгдсүгэй.

10.Хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон хэсэгчлэн гаргах эхний үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж Санхүүгийн зохицуулах хороо тооцсоноос хойш ажлын таван өдрийн дотор өрийн хэрэгслийн барьцаа хөрөнгө болох “Эс Ай Би Жэй капитал” ХХК-ийн эзэмшиж буй “Инвекор ББСБ” ХК-ийн 17,006,803 ширхэг хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд тусгаарлуулахыг “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ), “Инвекор ББСБ” ХК (Д.Баясгалан)-д тус тус үүрэг болгосугай.

11.Хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөгдөх хугацааг тухай бүр үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлсэн өдрөөс тооцох ба үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд “Барьцааны гэрээ”-ний дагуу зохих төлбөрийг төлж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж ажиллахыг “Эс Ай Би Жэй капитал” ХХК (Б.Анхболд), “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ), “Инвекор ББСБ” ХК (Д.Баясгалан)-д тус тус үүрэг болгосугай.

12.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

